



Монголбанк
Санхүүгийн мэдээллийн алба

Терроризмыг санхүүжүүлэхээс урьдчилан сэргийлэх нь

Ашгийн бус байгууллагад зориулав.



2022

Энэхүү гарын авлагыг мөнгө угаах эсвэл терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаатай холбоотой болзошгүй эрсдэлд санаатай болон санамсаргүй өртөхөөс сэргийлэх зорилгоор ашгийн бус байгууллагуудад зориулан боловсрууллаа. Тус гарын авлагатай АББ-ын удирдлагууд, үр шим хүртэгчид¹, ажилтнууд, сайн дурын ажилтнууд, итгэмжлэгдсэн төлөөлөгч² зэрэг бүхий л хамааралтай этгээдүүд танилцаж болно.



¹ АББ-ын буяны, хүмүүнлэгийн эсвэл бусад төрлийн тусламж авдаг хувь хүн эсвэл бүлэг хувь хүнийг хэлнэ.

² АББ-ын итгэмжлэгдсэн төлөөлөгч гэдэгт хорооны гишүүд, зөвлөлийн гишүүд, удирдах зөвлөлийн гишүүд, захирлууд багтаж болно.

АГУУЛГА

НЭГ. УДИРТГАЛ.....	3
ХОЁР. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ	4
ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ОЛОН УЛСЫН СТАНДАРТ	6
3.1. ФАТФ-ын шаардлага, олон улсын стандарт.....	6
3.2. Монгол Улсын эрх зүйн орчин.....	6
ДӨРӨВ. АББ-УУДЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭМЗЭГ СУЛ ТАЛ	10
ТАВ. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭД ЗҮЙ БУСААР АШИГЛАГДАХААС ХАМГААЛАХЫН ТУЛД АББ-УУДЫН АВЧ БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ	12
5.1. АББ-ууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд өртөхөөс сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ?.....	12
5.2. Ямар арга хэмжээ авч болох вэ?.....	13
ЗУРГАА. САЙН ТУРШЛАГА.....	14
ДОЛОО. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА	17
НАЙМ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ.....	20

НЭГ. УДИРТГАЛ

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт ашгийн бус байгууллага (АББ), тэдгээрийн үйл ажиллагааны чиглэл, гол зорилгыг урвуулан ашигласан тохиолдлууд гарч байна. Санхүүгийн хориг арга хэмжээг авах байгууллага (ФАТФ)-ын 2014 оны АББ-ыг терроризмыг санхүүжүүлэх зорилгоор хууль бусаар ашиглах эрсдэлийн тайланд дурдсанаар терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт АББ-ыг ашигласан нийт 102 кейсийг судалж, нийтлэг хэв шинжээр нь терроризмыг санхүүжүүлэх эрсдэл, аюул заналыг тодорхойлсон байна.

Тус судалгааны үр дүнгээр АББ-ын салбарын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эмзэг сул талууд нь хоорондоо харилцан уялдаа холбоотой байдаг бөгөөд террорист этгээдүүд нэгээс олон төрлийн эмзэг байдлыг ашиглахыг оролддог гэжээ. Мөн террорист этгээдүүд АББ-ын *санхүүжилтийг* урвуулан ашиглах нь тэдний гол арга хэрэгсэл байв. Түүнчлэн санхүүгийн бус арга хэлбэрээр буюу төсөл хөтөлбөрийг урвуулан ашиглах, ажилд зуучлахад дэмжлэг үзүүлэх гэх мэтээр АББ-ыг урвуулан ашиглах тохиолдлууд гардаг байна.

Терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй АББ-ууд нь үйлчилгээний салбарт үйл ажиллагаа эрхэлдэг, мөн террорист этгээдүүдтэй ойрхон үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд байна. Өөрөөр хэлбэл, террорист аюул заналхийлэл идэвхтэй байгаа мөргөлдөөнтэй бүс нутагт үйл ажиллагаа явуулж буй АББ-ууд өндөр эрсдэлтэй байна. Гэхдээ тухайн бүс нутгаас өөр газар үйл ажиллагаа явуулж байгаа ч террорист этгээдүүдэд дэмжлэг үзүүлэх, тэднийг хамгаалах зорилгоор нийгмийн дунд үйл ажиллагаа явуулдаг АББ-ууд ч багтаж байгаа юм. Аль ч тохиолдолд эрсдэлийн гол хувьсагч нь идэвхтэй террорист аюул заналхийлэлтэй хэр ойр байгаагаас /зөвхөн газар зүйн байршил биш/ хамаарч байна.

АББ-ыг урвуулан ашиглахыг таслан зогсоох, эрсдэлийг бууруулахад хариуцлага хүлээлгэх тогтолцоог сайжруулах, санхүүгийн зорилтот хориг арга хэмжээг авах, санхүүгийн шийтгэл ногдуулах зэрэг нь чухал ач холбогдолтой байна.

Түүнчлэн АББ-ууд нь мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх, урьдчилан сэргийлэх ойлголтоо сайжруулж, санаатай болон санамсаргүй байдлаар энэ төрлийн гэмт хэрэгт өртөх, оролцохоос сэргийлэх нь маш чухал юм.

ХОЁР. ЕРӨНХИЙ ОЙЛГОЛТ

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэх гэж юу вэ?

Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль болон Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуульд зааснаар:

- **Мөнгө угаах** гэж гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласныг, эсхүл түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлснийг, эсхүл түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсныг хэлнэ.
- **Терроризм** гэж гэж улс төр, шашин, үзэл суртал, эдгээртэй адилтгах бусад зорилгодоо хүрэхийн тулд төрийн байгуулал, нийгэм, эсхүл түүний тодорхой хэсэгт нөлөөлөн айдаст автуулахаар хүчирхийлэл үйлдэх, хүчирхийлэл үйлдэхээр заналхийлэх, гамшгийн нөхцөлийг бүрдүүлэх үйл ажиллагааг хэлнэ.
- **Терроризмыг санхүүжүүлэх** гэж террорист этгээд, террорист үйлдэл, үйл ажиллагаанд зарцуулагдахыг мэдсээр байж шууд болон шууд бусаар эд хөрөнгө хуримтлуулсан, өөрчилсөн, шилжүүлсэн, зарцуулсныг хэлнэ.
- **Террорист этгээд** гэж террорист, террорист байгууллагыг хэлнэ. **Террорист** гэж өөрийн хүсэл зоригоор, сайн дураар, санаатайгаар террорист үйл ажиллагааг шууд болон шууд бусаар үйлдэх, түүнд оролцож байгаа хүнийг хэлнэ. Харин **террорист байгууллага** гэж террорист үйл ажиллагааг шууд болон шууд бусаар үйлдэх, эсхүл түүнд оролцохоор өөрийн хүсэл зоригоор, сайн дураар, санаатайгаар нэгдсэн террористуудын аливаа бүлэг, нэгдлийг хэлнэ.

Террорист үйл ажиллагааг ихэвчлэн дараах эх үүсвэрээс олсон орлогоор санхүүжүүлдэг. Үүнд:

- Луйвар, залилан хийх
- Хар тамхи, зэвсгийн наймааны хууль бус худалдаа явуулах
- Ашгийн бус байгууллагыг урвуулан ашиглах
- Хүн барьцаалах, хулгайлах
- Цахим мөнгөөр хууль бус худалдаа хийх
- Газрын тос, нүүрс, алмаз, алт зэрэг бараагаар хууль бус худалдаа хийх гэх мэт.

Мөнгө угаах гэмт хэрэг болон терроризмыг санхүүжүүлэх гэмт хэргийн ялгаа нь:



Өөрөөр хэлбэл, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хууль бус орлогоос гадна хууль ёсны орлогыг ч зарцуулдаг байна. Үүний нэг хэлбэр нь АББ зэрэг албан ёсны хуулийн этгээдийн үйл ажиллагааг урвуулан ашиглах тохиолдлууд юм.

ГУРАВ. ЭРХ ЗҮЙН ОРЧИН БА ОЛОН УЛСЫН СТАНДАРТ

3.1. ФАТФ-ын шаардлага, олон улсын стандарт



ФАТФ-аас дэлхийн улс орнуудын мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх чиглэлээр хэрэгжүүлэх шаардлагатай иж бүрэн, цогц арга хэмжээний ерөнхий хүрээг тодорхойлон гаргадаг. Энэ хүрээнд ФАТФ-аас улс орнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх болон үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэхийг санхүүжүүлэхтэй тэмцэх техник хэрэгжилтийн 40 зөвлөмж, 11 шууд хэрэгжилтийг хангаж ажиллахыг шаарддаг. Үүний нэг нь Зөвлөмж 8 буюу АББ-ыг террорист үйл ажиллагаа, терроризмыг санхүүжүүлэхэд урвуулан ашиглахаас сэргийлэх шаардлагатай гэж заадаг.

ФАТФ-ын Зөвлөмж 8-аар тодорхойлсон АББ гэдэг нь:

АББ гэдэг нь буяны, шашны, соёлын, боловсролын, нийгмийн, нийгэмлэгийн зорилгоор эсвэл бусад төрлийн “сайн үйлс”-ийн үйл ажиллагааг эрхлэх зорилгоор хөрөнгө босгох, зарцуулах чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг хуулийн этгээд, эрх зүйн бусад зохицуулалттай хуулийн этгээдийг хэлнэ.

Зөвлөмж 8 нь энгийн ашгийн бус үйл ажиллагаа явуулж байгаа үндэслэлээр бус харин терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх өндөр эрсдэлтэй ашгийн бус байгууллагын үйл ажиллагаа, шинж чанарт үндэслэсэн стандартаар зохицуулдаг. Иймд Зөвлөмж 8-ын хүрээнд бүх АББ-ыг хамруулж зохицуулдаггүй болно.

Зөвлөмж 8-ын зорилго бол террорист байгууллага нь АББ-ыг дараах байдлаар хууль бус үйл ажиллагаанд урвуулан ашиглахаас сэргийлэхэд чиглэгдсэн. Үүнд:

- (i) хууль ёсны байгууллагын нэрийг ашиглах;
- (ii) хууль ёсны этгээдийг терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах (үүнд хөрөнгө царцаахаас зайлсхийх явдал мөн хамаарна);
- (iii) хуулийн дагуу зарцуулагдах хөрөнгө мөнгийг нуун далдалж, зориулалтыг нь өөрчлөх замаар террорист бүлэглэлд ашиглах.

3.2. Монгол Улсын эрх зүйн орчин

Монгол Улсын Үндсэн хуулийн Арван зургаадугаар зүйлийн 10-т “нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс нам, олон нийтийн бусад байгууллага байгуулах, сайн дураараа эвлэлдэн нэгдэх эрхтэй. Нам, олон нийтийн бусад бүх байгууллага

нийгэм, төрийн аюулгүй байдлыг сахиж, хуулийг дээдлэн биелүүлнэ. Аль нэгэн нам, олон нийтийн бусад байгууллагад эвлэлдэн нэгдсэний төлөө болон гишүүний нь хувьд хүнийг ялгаварлан гадуурхах, хэлмэгдүүлэхийг хориглоно. Төрийн зарим төрлийн албан хаагчийн намын гишүүнийг түдгэлзүүлж болно” гэж заасан.

1997 онд батлагдсан Төрийн бус байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “төрийн бус байгууллага гэж иргэд, төрийн байгууллагаас бусад хуулийн этгээдээс нийгмийн болон өөрсдийн ашиг сонирхол, үзэл бодлын үүднээс сайн дурын үндсэн дээр байгуулагдан үйл ажиллагаагаа төрөөс хараат бус, өөрийгөө удирдах зарчмаар явуулдаг ашгийн төлөө бус байгууллага” гэж заасан болно.

Дээрх зохицуулалтаас харахад Монгол Улсын Үндсэн хуулиар хүний эвлэлдэн нэгдэх эрхийг баталгаажуулан тогтоож, төрийн бус байгууллагатай холбоотой нарийвчилсан зохицуулалтыг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулсан бөгөөд төрийн байгууллагаас бусад ашиг олох зорилгогүй байгууллагыг төрийн бус байгууллагад хамруулж ойлгохоор байна. Өөрөөр хэлбэл, “ТББ” гэдэгт улс төрийн нам, үйлдвэрчний эвлэл, шашны байгууллага төдийгүй боловсрол, соёл урлаг, хэвлэл мэдээллийн гээд бүхий л салбарт ашиг олох зорилгогүйгээр нийтийн болон гишүүдийн сайн сайхны төлөө үйл ажиллагаа явуулж байгаа төрийн байгууллагаас бусад байгууллагыг хамааруулахаар өргөн хүрээгээр ойлгоно.

Түүнчлэн Төрийн бус байгууллагын тухай хуулийн 3 дугаар зүйлд “энэ хууль нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийдээс бусад төрийн бус байгууллагад хамаарна” гэж заасан нь нам, үйлдвэрчний эвлэл, сүм хийд нь төрийн бус байгууллага боловч тэдгээрийн эрх зүйн байдал, холбогдох харилцааг өөр хуулиар зохицуулах тул эдгээрээс бусад төрийн бус, ашгийн бус байгууллагуудтай холбоотой харилцааг Төрийн бус байгууллагын тухай хуулиар зохицуулахаар заасан болно. Уг хуулиар иргэн, хуулийн этгээдийн үүсгэл санаачлага бүхий ашгийн төлөө бус байгууллагын зохион байгуулалт, түүнд тавигдах шаардлага, бүртгэл, санхүүжилт, эрх, үүргийг тодорхойлсон.

Төрийн бус байгууллага байгуулах, эвлэлдэн нэгдэх иргэний үндсэн эрх нь Иргэний хууль (2002), Төрийн бус байгууллагын тухай хууль (1997), Улс төрийн намын тухай хууль (2005), Үйлдвэрчний эвлэлүүдийн эрхийн тухай хууль (1991), Монголын улаан загалмайн нийгэмлэгийн эрх зүйн байдлын тухай хууль (2016), Төр сүм хийдийн харилцааны тухай хууль (1993), Худалдаа, аж үйлдвэрийн танхимын тухай хууль (1995) Нотариатын тухай хууль (2011), Шинжлэх ухааны академийн эрх зүйн байдлын тухай хууль (1996), Боловсролын тухай хууль (2002), Соёлын тухай хууль (1996), Биеийн тамир, спортын тухай хууль (2017), Арбитрын тухай хууль (2017) Сууц өмчлөгчдийн эрх зүйн байдал, нийтийн зориулалттай орон сууцны байшингийн дундын өмчлөлийн эд хөрөнгийн тухай хууль (2013) болон бусад холбогдох хууль тогтоомжоор хангагдаж байна.

Дээр дурдсан хуулиудаас гадна АББ-ын харилцаатай холбоотой асуудлыг дараах хууль, эрх зүйн актаар зохицуулж байна:

- Хуулийн этгээдийн бүртгэлийн тухай хууль (2018)
- Зөрчлийн тухай хууль (2017);
- Зөрчил шалган шийдвэрлэх тухай хууль (2017);
- Эрүүгийн хууль (2015);
- Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хууль (2017);
- Гадаадын иргэний эрх зүйн байдлын тухай хууль (2010);
- Засгийн газрын тухай хууль (1993);
- Хууль тогтоомжийн тухай хууль (2015);
- Жагсаал цуглаан хийх журмын тухай хууль (1994) ;
- Мэдээллийн ил тод байдал, мэдээлэл авах эрхийн тухай хууль (2011);
- Нэмэгдсэн өртгийн албан татварын тухай хууль (2015);
- Мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх тухай хууль (2013);
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хууль (2019);
- Иргэдээс төрийн байгууллага, албан тушаалтанд гаргасан өргөдөл, гомдлыг шийдвэрлэх тухай (1995) гэх мэт байна.

Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасны дагуу АББ нь зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос сэргийлэх талаар дараах үүрэг хүлээнэ:

- зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн байгууллагад даруй өгөх;
- террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх;
- терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх;
- терроризмоос сэргийлэх, террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх.

Түүнчлэн дээрх хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь заалтаар хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй харилцаа тогтоож болох эсэх асуудлыг дараах байдлаар хязгаарласан болно. Үүнд:

- Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүү, бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлэхийг хориглоно.

Хориг арга хэмжээг хэрэгжүүлэх нийтлэг журмыг Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлээр зохицуулсан бөгөөд хүн, хуулийн этгээд дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх тухай хуулийн 23 дугаар зүйлийн 23.6-т заасны дагуу хүн, хуулийн этгээд аливаа үйлчилгээ үзүүлэхдээ хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн шууд болон шууд бус өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцааж тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлнэ.
- Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмтой тэмцэх санхүүгийн зорилтот хориг арга хэмжээ авах үйл ажиллагааны журмын 5.1 дэх хэсэгт заасны дагуу хүн, хуулийн этгээд нь хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийн шууд болон шууд бус өмчлөлд байгаа хөрөнгө, ашиг орлогын хөдөлгөөнийг тухайн этгээдэд урьдчилан мэдэгдэлгүйгээр нэн даруй зогсоож, тагнуулын байгууллага болон санхүүгийн мэдээллийн албанд даруй мэдэгдэнэ.

ДӨРӨВ. АББ-УУДЫН МӨНГӨ УГААХ, ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭМЗЭГ СУЛ ТАЛ

АББ-ыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор урвуулан ашиглах нь АББ-ын санхүүжилтийг ашиглах, хөрөнгийг урвуулан ашиглах, АББ-ын нэр, статусыг буруугаар ашиглах, хууль бус зорилгоор АББ байгуулах зэрэг янз бүрийн хэлбэртэй байдаг. АББ-ын засаглалын бүтэц, санхүүгийн хяналт сул байгаа үед дээрх төрлийн эрсдэл тохиолдох магадлал нэмэгддэг.

АББ-ууд нь олон төрлийн үйл ажиллагаагаар дамжуулан нийгмийн бүхий л хэсэгт хүрч үйлчлэхээс гадна АББ-уудад итгэх олон нийтийн итгэл үнэмшил өндөр байдаг. Энэхүү шинж чанар нь террорист этгээд, мөнгө угаах бүлэглэлүүдийг АББ-ыг урвуулан ашиглах нөхцөл боломжийг бүрдүүлэхэд нөлөөлдөг байна.

Санхүүжилтийн эх үүсвэр хязгаарлагдмал тул АББ-ууд нь өөсдийн дотоод засаглал, үйл ажиллагаатай холбоотой зардлаа аль болох бага байлгаж, харин хэрэгжүүлж байгаа төсөл хөтөлбөрүүддээ санхүүжилтээ илүү зарцуулах хандлагатай байдаг. Үүний үр дүнд зарим АББ-уудын санхүүгийн удирдлагын тогтолцоо хангалттай сайн бүрдээгүй байдгаас болж хандивлагч байгууллагын хандивласан хөрөнгийн эх үүсвэрийг хууль ёсны эсэх эсвэл хүлээн авагч байгууллагууд хөрөнгийг хууль ёсны зорилгоор ашиглаж байгаа эсэхийг баталгаажуулж чадахгүй тохиолдлууд гардаг байна.

Олон улсын хэмжээний АББ-уудын хувьд тэдний үйл ажиллагаа явуулж буй зарим нутаг дэвсгэрүүдэд хяналтын тогтолцоо сул, мөн зарим АББ-ууд санхүүгийн зохицуулалтгүй сувгаар дамжуулан хөрөнгө мөнгийг шилжүүлдэг. Тухайлбал, мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх өндөр эрсдэлтэй улс орнуудад үйл ажиллагаа явуулах нь террористуудыг санхүүжүүлэх эрсдэлд өртөх эрсдэлийг нэмэгдүүлдэг байна.

АББ-ууд хэрхэн терроризмыг санхүүжүүлэх эрсдэлд өртдөг вэ?

Мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх зорилгоор АББ-ын салбарын онцлог шинж чанарыг харгалзан төрөл бүрийн хэлбэрээр АББ-уудыг урвуулан ашигладаг. Тухайлбал,

Санхүүжилт болгож ашиглах

Хувь хүмүүс санаатай болон санамсаргүй байдлаар террорист үйл ажиллагааг дэмжихэд хувь нэмэр оруулж, АББ-ын нэрээр хөрөнгө босгохын тулд хандив цуглуулагчийн үүрэг гүйцэтгэдэг. Хандиваар цуглуулсан хөрөнгийг терроризмын үйл ажиллагаанд зарцуулдаг бөгөөд төлөвлөсөн эзэддээ хүрч чадахгүй. Ийм байдлаар АББ-ыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд зарцуулах хөрөнгийг байршуулах, цэвэршүүлэх этгээд болгон ашигладаг байна.

АББ-ын нөөцийг ашиглах

Террорист байгууллагын үйл ажиллагааг дэмжигч хүмүүс нь эрсдэл өндөртэй бүс нутагт террорист этгээдүүдтэй холбоо тогтоохын тулд АББ-ын ажилтны хувиар ажилладаг байна. АББ нь мэдсээр байж эсвэл мэдээгүй байх тохиолдлуудад ч дээрх байдлаар өөрсдийгөө харилцаа холбооны сүлжээ болгож ашиглуулсан байдаг.

АББ-ын нэрийг буруугаар ашиглах

Бүртгэлгүй АББ нь бүртгэлтэй АББ-тай ижил төстэй нэр, холбоо барих хаягийг

ашиглан олон нийтийг төөрөгдүүлдэг байна. Ийм зорилготой АББ-уудын удирдах албан тушаалтнууд эцсийн дүндээ террорист байгууллагуудтай холбоотой байдаг.

АББ-ыг хуурамчаар байгуулах

Террористууд мөнгө цуглуулах, үйл ажиллагаагаа сурталчлах, терроризмыг дэмжих үйл ажиллагаа явуулах замаар хуурамч АББ байгуулахыг оролддог. АББ-ыг хууль бус хөрөнгийг угаахын тулд дагалдагч компани хэлбэрээр байгуулдаг байна.

ТАВ. ТЕРРОРИЗМЫГ САНХҮҮЖҮҮЛЭХЭД ЗҮЙ БУСААР АШИГЛАГДАХААС ХАМГААЛАХЫН ТУЛД АББ-УУДЫН АВЧ БОЛОХ АРГА ХЭМЖЭЭ

Өмнөх бүлгүүдэд АББ-уудын хууль, эрх зүйн орчин болон АББ-ууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт хэрхэн өртдөг талаар товч дурдлаа. Гуравдугаар бүлэгт дурдсан хууль тогтоомжуудын хэрэгжилтийг хангах, нэн ялангуяа АББ нь зэвсэг дэлгэрүүлэх болон терроризмоос сэргийлэх, хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдтэй харилцаа тогтоохоос урьдчилан сэргийлэхийн тулд дараах зүйлсийг анхаарах шаардлагатай.

5.1. АББ-ууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхэд өртөхөөс сэргийлэхийн тулд юу хийх ёстой вэ?

АББ-ыг мөнгө угаах болон терроризмыг санхүүжүүлэхэд ашиглах эрсдэл нь тухайн байгууллагын эрсдэлээс хамааран өөр өөр байх бөгөөд АББ нь тулгарч болзошгүй эрсдэлийн мөн чанар, тэдгээрийн болзошгүй нөлөөлөл, үүсэх магадлалыг үнэлэх ёстой. АББ-ын эрсдэлийн профайлыг тодорхойлоход дараах хүчин зүйлс хамааралтай. Дараах асуултуудад АББ-ууд хариулж, өөрсдийн эрсдэлийг үнэлж, ойлгож, өөрсдийгөө эрсдэлээс хамгаалах шаардлагатай юм.

Үүнд:

- ✓ Танай байгууллагад ажилладаг итгэмжлэгдсэн төлөөлөгч, ажилчид, санхүүжүүлэгчид, сайн дурын ажилтнууд, мөн танай байгууллагын нэрийн өмнөөс ажиллаж байгаа бусад хүмүүс болон ойр ажилладаг бусад хүмүүсийн ерөнхий мэдээллийг мэддэг үү?
- ✓ Байгууллагын хөрөнгийг хэрхэн зарцуулж байгаа эсэхийг баталгаажуулж дотоод санхүүгийн хяналт хийдэг үү?
- ✓ Хөрөнгө хүлээн авсан, ашигласан үед санхүүгийн бүртгэлийг үнэн зөв, хангалттай бүртгэдэг үү?
- ✓ Танай байгууллага санхүүгийн албан ёсны сувгаар санхүүгийн гүйлгээ хийдэг үү? Жишээлбэл, банкны дансаар дамжуулан гүйлгээ хийдэг үү?
- ✓ Танай байгууллага эрсдэл өндөртэй улс орнуудад байгаа халхавч компаниуд болон хандивлагчдаас хандив авдаг уу? Хэрэв тийм бол холбогдох хандивлагчдад зохих харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлдэг үү?
- ✓ Танай байгууллага чухал хандивлагчиддаа харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг хэрэгжүүлж, хэн болохыг нь баталгаажуулах арга хэмжээ авдаг уу?

- ✓ Танай байгууллага зөвхөн дотоодод үйл ажиллагаагаа явуулдаг уу? Хэрэв үгүй бол мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэл өндөртэй орнуудад үйл ажиллагаагаа явуулдаг уу?
- ✓ Танай байгууллага үйл ажиллагаагаа явуулахдаа гуравдагч этгээдээр дамжуулдаг уу? Хэрвээ тийм бол гуравдагч этгээдэд ямар төрлийн хяналт тавьдаг вэ?

5.2. Ямар арга хэмжээ авч болох вэ?

Дээр дурдсанчлан АББ мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээг хийх ёстой байдаг. Эрсдэлийн үнэлгээг бүрэн хийгээгүй ч гэсэн хамгийн багадаа дараах зүйлсийг хийх шаардлагатай. Үүнд:

- Хөрөнгө, санхүүжилт хүлээн авсан, ашигласан талаарх санхүүгийн бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөх
- АББ-ын эцсийн өмчлөгчийн мэдээллийг үнэн зөв байлгах
- АББ-тай өмнө нь холбоо тогтоож байгаагүй хандивлагчаас их хэмжээний санхүүжилт авсан бол хэн болохыг нь баталгаажуулах арга хэмжээ авах хэрэгтэй. Хэрэв тухайн хандивлагч нь байгууллага бол ямар төрлийн үйл ажиллагаа эрхэлдэг эсэхийг баталгаажуулах шаардлагатай.
- Гуравдагч этгээдийг ашигладаг бол харилцагчийг таньж мэдэх үйл ажиллагааг зайлшгүй хийх гэх мэт.

ЗУРГАА. САЙН ТУРШЛАГА

АББ-ууд мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх гэмт хэрэгт өртөх, оролцох, ашиглагдахаас сэргийлж дараах туршлагуудыг өөрсдийн үйл ажиллагаандаа нэвтрүүлж болно. Үүнд:

1. Шилдэг туршлагыг нэвтрүүлэх:

- i) АББ-ууд хандивлагчид, үйлчлүүлэгчид буюу үр шим хүртэгчид, улс орны онцлог, газар зүйн бүс нутаг, бүтээгдэхүүн, үйлчилгээ, хүргэх сувгуудад учирч болох мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийг тодорхойлох, үнэлэх зохих арга хэмжээг авч, эрсдэлийн үнэлгээний үр дүнд үндэслэн эрсдэлийг бууруулах арга хэмжээ авбал зохино;
- ii) Ажилтнуудыг мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх талаарх сургалтад тогтмол /жил бүр/ хамруулах;
- iii) АББ нь хууль зөрчсөн аливаа үйл ажиллагаанд оролцохгүй байх.

2. Сайн засаглалыг бий болгох:

- i) Удирдлага нь гүйцэтгэх болон гүйцэтгэх бус удирдах зөвлөлийн гишүүн бүрийг нарийн ялгаж тодорхойлох хангалттай арга хэмжээ авах;
- ii) Удирдлагын зүгээс мөнгө угаах, терроризмыг санхүүжүүлэхтэй тэмцэх зорилтуудыг боловсруулж, хэрэгжүүлэх;
- iii) Эрсдэлд суурилсан аргачлалд үндэслэн АББ-ууд үйл ажиллагаандаа хараат бус хяналтын хороо байгуулах.

3. Ашиг хүртэгч болон хамтрагчаа таньж мэдэх:

- i) АББ-ууд бэлэн мөнгө, үйлчилгээ, ямар нэгэн хандив хүлээн авсан ашиг хүртэгчдийн мэдээллийг үнэн зөв, бүрэн тодорхойлох, таньж мэдэх;
- ii) Хүлээн авагч нь байгууллага байвал хандивлагч АББ-ууд нь тухайн байгууллагын талаар мэдээлэлтэй байх ёстой. АББ-ууд нь ашиг хүртэгчдийг терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаа эсвэл терроризмыг дэмжих сүлжээтэй холбоогүй эсэхийг нягтлах нь зүйтэй.

4. Хандивлагчаа таньж мэдэх:

- i) Хандивлагчаас мөнгө авахын өмнө хандивлагчийг НҮБ-ын Аюулгүйн зөвлөлийн хориг арга хэмжээний жагсаалтад ороогүй гэдгийг шалгаж, баталгаажуулах;

- ii) АББ нь томоохон хандивлагчдын бүртгэлийг үнэн зөв, бүрэн хөтлөж, хадгалах;
- iii) Хандивлагч байгууллага, тэдгээрийн удирдлага, албан тушаалтнуудыг гэмт хэрэгт холбогдсон, шалгагдаж байгаа эсэхийг нээлттэй мэдээллийн эх сурвалж ашиглан хайж болно. Ялангуяа терроризмтой холбоотой үйл ажиллагаа, терроризмыг санхүүжүүлэх үйл ажиллагаанд оролцож байсан эсэхийг хайж үзэх;
- iv) Хууль ёсны бус хөрөнгө гэж үзвэл АББ-ууд нь аливаа хандив, саналаас татгалзаж болно.

5. Ажилтнуудаа таньж мэдэх:

- i) АББ нь ажилтнуудынхаа бичиг баримтын хуулбар, байнгын хаяг, иргэний харьяалал, цахим шуудангийн хаяг, гар утасны дугаар зэрэг ерөнхий мэдээллийг мэддэг, хадгаладаг байх;
- ii) АББ-ууд шинээр ажилтан авахдаа тухайн хүнийг өмнө нь ямар төрлийн ажил хийж байсан эсэхийг нягтлах;
- iii) Удирдлага нь ажилтнуудынхаа амьдралд болж буй өөрчлөлтүүд, тэдэнд ямар нэгэн дарамт шахалт байгаа эсэхэд сэрэмжтэй байх.

6. Ил тод байдал, санхүүгийн хариуцлагатай байдлыг хангах

- Хандив хүсэх - Хандивын аливаа хүсэлтэд хөрөнгө босгох зорилго, хэрхэн, хаана зарцуулах зэргийг тодорхой тусгасан байх ёстой бөгөөд улмаар уг санхүүжилтийг хууль ёсны дагуу ашиглаж байгаа эсэхийг шалгах боломжтой болно.
- Хандив, мөнгөн хөрөнгө хүлээн авах, зарцуулах:
 - АББ нь бүх хандив, мөнгөн мөнгийг зохицуулалттай санхүүгийн салбараар дамжуулан хийх буюу бэлэн мөнгөний гүйлгээг аль болох бага ашиглах. Хэрэв бэлэн мөнгө ашиглавал бэлэн мөнгөний гүйлгээний дэлгэрэнгүй дотоод бүртгэлийг хөтөлж болно.
 - АББ нь туслалцаа авч байгаа этгээдийн нэр, мэдээлэл, олгосон дүн, төлбөрийн огноо зэрэг мэдээллийг хөтөлж, хадгаладаг байх.
 - АББ-ын ажилтнууд сэжигтэй хандивыг танидаг байх, хэрэв сэжигтэй байвал юу хийхээ мэддэг байх.
- Сангийн ашиглалт - Гадаад улсаас албан ёсоор хандив авдаг АББ-ууд эдгээр хөрөнгийг нийтийн сайн сайхны төлөө зохистой зарцуулдаг эсэх, өөрсдийн засаглал, санхүүжилтийн урсгалд зохих хяналтын тогтолцоотой эсэх, тэдгээрийн ил тод байдлыг хангадаг байх.

- Дотоод аудит - АББ-ууд эрсдэлийг тодорхойлох, төлөөлөн удирдах зөвлөлд эрсдэлийн удирдлагын үр нөлөө, дотоод хяналт, засаглалын үйл явцын талаар мэдээлэл өгөхөд туслах дотоод аудитын чиг үүргийг бий болгож болно.

ДОЛОО. ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

АББ нь анх байгуулагдсан цагаас эхлэн Монгол Улсын хуулийн этгээд болохын хүрээнд түүнд холбогдох бүхий л хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах шаардлагатай болдог. Тухайлбал, Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хуулийн дагуу шинээр байгуулагдсан хуулийн этгээд нь улсын бүртгэлийн байгууллагад өргөдөл гаргаж, бүртгүүлнэ. Мөн хуулийн этгээд болохын хүрээнд санхүүгийн тайланг татварын албанд хүргүүлэх үүрэг хүлээнэ гэх мэт хүлээх үүрэг хариуцлагынхаа талаар мэдлэгтэй байх нь та бүхнийг ирээдүйд гарч болзошгүй эрсдэлээс хамгаалах болно.

АББ-ын үйл ажиллагааны хүрээнд хамаарах хууль тогтоомжийн хариуцлагын заалтуудаас дурдвал:

Зөрчлийн тухай хуулиар:

- Төрийн бус байгууллагын тухай хууль зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 11.7 дугаар зүйлд заасны дагуу Төрийн бус байгууллагын орлогоос:
 1. ногдол ашиг хуваарилсан;
 2. иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын төлбөрийг төлсөн бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгоно.
 - Төрийн бус байгууллагын удирдах зөвлөлийн гишүүн, ажилтнаас тухайн байгууллагын эд хөрөнгөөр хувийн ашиг олох зорилгоор санхүүгийн, эсхүл аж ахуйн үйл ажиллагаа явуулсан бол хууль бусаар олсон хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгоно.
 - Хуульд заасан хугацаанд үйл ажиллагааныхаа тайланг холбогдох эрх бүхий байгууллагад гаргаж өгөөгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 20,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000 төгрөгөөр торгоно.
-
- Тамга тэмдэг үйлдвэрлэх, хэрэглэх, хадгалах журам зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 10.20 дугаар зүйлд зааснаар хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгоно.
 - Улсын бүртгэлд бүртгүүлэх журам зөрчсөн бол Зөрчлийн тухай хуулийн 15.23 дугаар зүйлд зааснаар улсын бүртгэлд бүртгүүлэхээр мэдүүлэг гаргагч:
 1. хуульд заасан үүргээ биелүүлээгүй /хуульд заасан хугацаанд бүртгүүлээгүй бол/;
 2. хуульд заасан улсын бүртгэлийн мэдүүлэг, өргөдөл, хүсэлт, хавсаргасан нотлох баримтыг үнэн зөв мэдүүлээгүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж хүнийг 50,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 500,000 төгрөгөөр торгоно.

- Хуулийн этгээдийн улсын бүртгэлийн тухай хууль 26 дугаар зүйлийн 26.1-г зааснаар санхүүгийн тайлангаа найм ба түүнээс дээш улирал дараалан гаргаагүй, харилцагч санхүүгийн байгууллагад илгээж баталгаажуулаагүй хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасах талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын саналыг үндэслэн улсын бүртгэлийн байгууллага өөрийн цахим хуудсаар нийтэд зарлах бөгөөд зарласнаас хойш 6 сарын дотор бичгээр санал, гомдол гаргаагүй, дампуурлын хэрэг үүсгээгүй, санхүүгийн тайлангаа гаргаагүй, шүүхийн шийдвэрээр тогтоогдсон өр, төлбөргүй бол уг хуулийн этгээдийг улсын бүртгэлээс хасна.
- Зөрчлийн тухай хуулийн 5.10 дугаар зүйлийн дагуу:
 - Терроризмтой холбоотой мэдээ, мэдээллийг төрийн холбогдох байгууллагад даруй өгөх, эсхүл террорист үйлдэл, үйл ажиллагаанд өдөөн хатгасан аливаа явуулга, суртал ухуулга, үзэл санаанд автахгүй байх, терроризмыг сурталчлах, олон нийтэд уриалах, нийтийн өмнө зөвтгөх аливаа үйл ажиллагаа явуулахгүй байх, терроризмоос сэргийлэх, эсхүл террорист үйлдлийн сөрөг тусгай ажиллагааг явуулах, хохирол, хор уршгийг арилгах, сэргээн босгох ажиллагаанд дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг 20,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгоно.
 - Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээдийг шууд болон шууд бусаар санхүүжүүлэх, эсхүл түүнд эдийн засгийн эх үүсвэр олгох, санхүүгийн болон бусад бүх төрлийн үйлчилгээ, туслалцаа, дэмжлэг үзүүлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол зөрчил үйлдэхэд ашигласан хөрөнгө, орлогыг хурааж хүнийг 20,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгоно.
 - Зөвлөлийн терроризмоос сэрэмжлүүлэх талаар өгсөн үүрэг, эсхүл Шуурхай штабын хүсэлт, шаардлагыг хүн, хуулийн этгээд даруй биелүүлэх, эсхүл түүнд бүх талын дэмжлэг, туслалцаа үзүүлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг 20,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгоно.
 - Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг даруй царцаагаагүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол царцаагаагүй хөрөнгийн үнийн дүнтэй тэнцэх хэмжээний хөрөнгө, орлогыг хурааж, хүнийг 20,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгоно.
 - Хориг арга хэмжээний болон дотоодын жагсаалтад орсон хүн, хуулийн этгээд, тэдгээрийг санхүүжүүлдэг этгээдийн өмчлөл, эсхүл хяналтад байгаа хөрөнгийг

тагнуулын байгууллагад 24 цагийн дотор мэдээлэх үүргээ биелүүлээгүй бол хүнийг 20,000,000 төгрөгөөр, хуулийн этгээдийг 200,000,000 төгрөгөөр торгоно.

Эрүүгийн хуулиар:

- Эрүүгийн хуулийн 18.6-д зааснаар гэмт хэргийн улмаас олсон хөрөнгө, мөнгө, орлого гэдгийг мэдсээр байж түүнийг авсан, эзэмшсэн, ашигласан; түүний хууль бус эх үүсвэрийг нь нуун далдлах, гэмт хэрэг үйлдэхэд оролцсон аливаа этгээдэд хуулийн хариуцлагаас зайлсхийхэд туслах зорилгоор өөрчилсөн, шилжүүлсэн; түүний бодит шинж чанар, эх үүсвэр, байршил, захиран зарцуулах арга, эзэмшигч, эд хөрөнгийн эрхийг нуун далдалсан бол 6 сар-1 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 6 сар-1 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Мөнгө угаах гэмт хэргийг:
 - 2.1.энэ хуулийн тусгай ангид хорих ялын доод хэмжээг 5 жилээс дээш хугацаагаар тогтоосон гэмт хэрэг үйлдэж олсон хөрөнгө, мөнгө, орлого болохыг мэдсээр байж;
 - 2.2.байнга тогтвортой үйлдэж;
 - 2.3.албан тушаалтан албаны чиг үүрэг, бүрэн эрх, нөлөөг урвуулан ашиглаж үйлдсэн бол 1-5 жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл 1-5 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
 - Мөнгө угаах гэмт хэргийг зохион байгуулалттай гэмт бүлэг үйлдсэн бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.
 - Мөнгө угаах гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх хасаж 120,000,000-400,000,000 төгрөгөөр торгох ял шийтгэнэ.
-
- Эрүүгийн хуулийн 29.3-т зааснаар Монгол Улсын олон улсын гэрээгээр хориглосон хими, биологийн, эсхүл үй олноор хөнөөх бүх төрлийн зэвсэг, тэдгээрийн түүхий эд, эд зүйл, тоног төхөөрөмж, технологийг боловсруулсан, үйлдвэрлэсэн, хуримтлуулсан, олж авсан, худалдсан бол 5-12 жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ. Үй олноор хөнөөх зэвсэг дэлгэрүүлэх гэмт хэргийг хуулийн этгээдийн нэрийн өмнөөс, хуулийн этгээдийн ашиг сонирхлын төлөө үйлдсэн бол хуулийн этгээдийг тодорхой төрлийн үйл ажиллагаа явуулах эрх 120,000,000-400,000,000 төгрөгөөр торгох ял шийтгэнэ.

НАЙМ. АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- **Anti-money laundering/countering the financing of terrorism guidelines for NPOs**, Securities & Exchange Commission of Pakistan, National Counter Terrorism Authority of Pakistan, 2018, <https://www.ndrmf.pk/wp-content/uploads/2020/06/AML-CFT-Guidelines-for-NPOs-2018.pdf>
- **Best Practices on Combating the Abuse of Non-Profit Organisations**, FATF, 2015, <https://www.fatf-gafi.org/en/publications/Financialinclusionandnpoissues/Bpp-combating-abuse-npo.html>
- **Guidance on Anti-Money Laundering and Counter-Terrorist Financing for Charities**, Charities Regulator, 2020, <https://www.charitiesregulator.ie/media/1909/guidance-on-anti-money-laundering-and-counter-terrorist-financing-for-charities.pdf>
- **Protecting your charity against money laundering and terrorist financing**, Office of the Commissioner of Charities, 2021, <https://www.charities.gov.sg/PublishingImages/Resource-and-Training/Guides-Templates-Awards/Guides/Documents/Protecting%20your%20Charity%20against%20Money%20Laundering%20and%20Terrorist%20Financing%20-May%202015.pdf>
- **Risk of terrorist abuse in non-profit organisations**, FATF, 2015, <https://www.fatf-gafi.org/en/publications/Methodsand trends/Risk-terrorist-abuse-non-profits.html>
- **The FATF Recommendations**, FATF 2022, <https://www.fatf-gafi.org/en/publications/Fatfrecommendations/Fatf-recommendations.html>
- **Монгол Улсын Ашгийн бус байгууллагын салбарын терроризмыг санхүүжүүлэх эрсдэлийн үнэлгээний тайлан**, ХЗДХЯ, 2020